



20

МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2003 оны 04 сар 10 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

**Сургууль хоорондын кредитийн тооцоо
хийх журам батлах тухай**

Ректорын зөвлөлийн 2003 оны 04-р сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТУШААХ** нь:

1. ШУТИС-ийн сургуулиуд хоорондын кредитийн тооцоо хийх журмыг хавсралтаар баталж, 2003 оны 04-р сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.


2. Оюутнуудын кредит баталгаажуулсан тушаалыг хичээлийн улирал бүрийн VII долоо хоногт шуурхай, үнэн зөв гаргаж сургууль хоорондын кредитийн тооцоог журамд заасан хугацаанд бүрэн хийж дуусгаж байхыг сургуулийн захирал, нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

3. Сургууль хоорондын кредитийн тооцоог бүрэн барагдуулалгүйгээр барилгын засвар тохижилт хийх, тавилга, тоног төхөөрөмж худалдаж авахыг хатуу хориглож, тогтоосон хугацаанд сургууль хоорондын кредитийн тооцоог хийгээгүй захирал, нягтлан бодогч нарт тухай бүрт нь хариуцлага тооцож байхыг Сургалтын болон Захиргаа, эдийн засгийн проректоруудад даалгасугай.



РЕКТОР

Д.БАДАРЧ



Ректорын 2003 оныр сарын 94 ний өдрийн тоот тушаалын хавсралт

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн сургуулиуд хооронд кредитийн тооцоо хийх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

ШУТИС-ийн багш нараас бусад сургуулиуддаа суурь боловсролын болон, мэргэжлийн суурь хичээлүүд, мэргэшүүлэх хичээлүүдийг заах үед оюутны кредитийн төлбөрийг сургууль хооронд хуваарилан тооцоо хийхэд энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Тооцоо хийх зарчим

2.1 Сургууль хооронд хичээл заасан багш нарын гүйцэтгэсэн кредитийн төлбөрийн тооцоог тухайн хичээлийн кредит, сонгосон оюутны тоонд үндэслэн хийнэ.

$$\text{Нийт кредит} = \text{Тухайн хичээлийн кредит} \times \text{Сонгосон оюутны тоо}$$

2.2 Тухайн хичээлийг сонгосон оюутны сургалтын төлбөрөөс хичээл заасан багшид ноогдох зардлыг 3.1-ийн дагуу тооцож хуваарилна.

$$\text{Тухайн хичээлийг сонгосон оюутнуудын төлбөр} = \text{Нийт кредит} \times \text{Оюутны нэг кредитийн үнэлгээ}$$

Багшийг дагалдах зардал нь үндсэн хоёр хэсгээс бүрэлдэнэ.

Үүнд:

1. Багшийн гүйцэтгэсэн кредит цагийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулагдах зардал.
Энэ зардал нь хичээлийн онцлог, лекц, семинар, лабораторийн харьцаа, ангийн оюутны тоо, багшийн 1 кредитийн дундач үнэлгээ зэргээс хамаарч хичээл бүрт харилцан адилгүй байна.
2. Тухайн хичээлийг заасан багшийг дагалдах зардал.
Багшийг дагалдах зардлын оюутны нийт төлбөрт эзлэх хувийн жинг лабораторитой хичээлүүдэд-18%, лабораторигүй хичээлүүдэд-15% гэж тус тус ижилхэн тооцно.

Гурав. Сургууль хоорондын тооцоог хийх

3.1 Оюутны нийт төлбөрт эзлэх багшийг дагалдах зардлын хувийн жинг дараах байдлаар бодож хуваарилна.

Үүнд:

3.1.1 А. Суурь боловсролын хичээл

1. Гадаад хэлний хичээлд 54%
2. Математикийн хичээлд 42%
3. Бусад хичээлүүд
 - а. лабораторитой хичээлд 50%
 - б. лабораторигүй хичээлд 40%
 - в. биеийн тамирын хичээлд 100%

3.1.2 Б. Мэргэжлийн суурь хичээлүүд

- а. лабораторитой хичээлд 57%

б. лабораторигүй хичээлд 54%

3.1.3 В. Мэргэшүүлэх хичээл

Бүх хичээлүүдэд 63%

3.1.4 Тухайн хичээлийг гэрээт (цагийн) багш нар заасан тохиолдолд багшийг дагалдах зардлын 2-р хэсгийг хасч тооцоо хийнэ.

3.1.5 Тухайн хичээлийг үзсэн оюутны тоог тухайн сургуулийн захирлын кредит баталгаажуулсан тушаалыг үндэслэн тогтооно.

Дөрөв. Тооцоог дуусгах хугацаа

4.1 Сургуулиуд хоо рондын кредитийн намрын улирлын мөнгөний тооцоог 12-р сарын 25-ний дотор, хаврын улирлын мөнгөний тооцоог 05-р сарын 25-ний дотор багтаан бүрэн хийж дуусгана.